



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 29-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-10</i>

1. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

6-10

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 29-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 17 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;

Нэг. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Б.Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Судалгаа шинжилгээний албаны ажилтан Л.Хангарьд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал/

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах

санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг тус тус Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0

Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг тус тус Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0

Бүгд: 10

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “хугацаанаас өмнө” гэсний өмнө “шүүхийн магадлалаар” гэж нэмэх.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу дараах санал хураалтыг явуулна:

1.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасаж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийн урсгал зардлын хэмжээг өмнөх оны батлагдсан төсвөөс бууруулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0

Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “хугацаанаас өмнө” гэсний өмнө “шүүхийн магадлалаар” гэж нэмэх.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу дараах санал хураалтыг явуулна:

1.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасаж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийн урсгал зардлын хэмжээг өмнөх оны батлагдсан төсвөөс бууруулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	0
Бүгд:	10

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржоос ирүүлсэн хүсэлт /Улсын Их Хуралд 2023.06.27-ны өдөр ирүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ц.Нанзаддоржоос Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт ирүүлсэн хүсэлт болон энэ талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т заасны дагуу санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржийн 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн өөрийнх нь хүсэлтийг дэмжиж, чөлөөлье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	1
Бүгд:	10

90.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 21 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 13 цаг 17 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл эцсийн хэлэлцүүлэг.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржоос ирүүлсэн хүсэлт Ийм 2 асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1, 42.2.3-д заасныг баримтлан 2 саналын томъёоллыг бэлтгэсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгын төсөл зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан. Хуралдаанд одоо ажлын хэсгийн, дэд хэсгийн гишүүд бүрэн хүрэлцэн ирсэн байна.

Тогтоолын эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбоотойгоор гишүүдэд асуулт байна уу? Раднаасэд гишүүнээр тасаллаа.

Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Төсвийн ерөнхийлөн захирагчийг сонсголоор хэлэлцэнэ гээд явчихсан уу? Өчигдөр санал дотор. Би одоо буруу уншаагүй бол тэгж уншсан. Энэ нөгөө Засгийн газрын гишүүд чинь одоо бүгд ерөнхийлөн захирагч шүү дээ. Ерөнхий сайд нь оруулаад ирдэг. Заавал сонсгол хийнэ гэдэг. Аймгийн Засаг дарга

нар байна. Сонгуулийн үр дүнгээр гараад ирдэг. Тийм би буруу ойлгочихсон уу эс үгүй бол.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Өчигдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн эхний хэлэлцүүлгийг хийсэн.

Энд саналын томъёоллын 22 дахь саналын томъёололд хөтөлбөрийн 7.1.11-д өөрчлөн найруулах саналын томъёолол хураагдсан байна. Төсвийн захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөр өрсөлдүүлэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулж төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулж хэвшинэ гэсэн ийм заалт байна. Дэмжигдсэн байна.

Энэ дээр бол таны хэлсэнчлэн одоо бүх улс төрийн албан тушаалууд буюу нэгэнт Үндсэн хуулиар хуульчлагдсан аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндсэн хуульчлагдсан Засгийн газрын гишүүдэд энэ асуудал бичих нь бас Үндсэн хуулийн үзэл баримтлалтай бас хэр нийцэх вэ гэдэг ийм зарчмын асуудлыг бас хөндөж байна.

Тийм учраас саяын хэлсэнчлэн 7.1.11-ийг энэ ер нь хасах юм байна л даа.

Төсөл нь угаасаа яг ийм заалттай. Энэ найруулгын санал л өөрчлөгдсөн юм байна. Төсөл нь өөрөө ийм ийм байна. Тэгвэл хасах санал гаргачихъя. Тийм байна. 3-ны 2-оор хураана биз дээ.

Би төслийнх нь заалтыг нь уншаад өгчихье. Төслийнх нь.

Төсөл нь ийм ийм юм байна 7.1.11.

Төсөв захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг тухайн албан тушаалд

нэр дэвшүүлэхдээ бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг өрсөлдүүлэх зарчмыг баримталж сонгон шалгаруулалтыг явуулж, ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонголт зохион байгуулж хэвшинэ гэж яг адилхан. Энэ найруулгын л засвар хийсэн байгаа байхгүй юу. Баасаньямаас бүсгүйн хамгийн шалгалт Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар анхны хэлэлцүүлэг дээр энэ асуудал яригдаагүй учраас санал хураагдаад дэмжигдчихсэн асуудал дээр 3-ны 2-оор дахин санал хураах боломж байхгүй байгаа юм байна. Дэгийн хуулиараа бол.

Тэгэхээр энийг бол протоколд тэмдэглүүлчихье. Протоколд тэмдэглээд Мөнхбаатар дарга бас байж байна. Энийг Байнгын хорооны санал, дүгнэлтэд оруулаад 7.1.11 болон Монгол Улсын Үндсэн хуульд нэгэнт заасан Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн засагт хамаарахгүй гэдэг агуулга яригдсан гэдэг зүйлийг Байнгын хорооны протоколд тэмдэглээд Байнгын хорооны санал, дүгнэлтэд бас оруулах оруулахаар шийдье. Энэ бол яах вэ тэгэхдээ тогтоол байгаа.

Яг хууль бол бас биш. Энийг одоо Засгийн газар өөрөө энэ тогтоолоор төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газарт одоо боловсруулаад 10 сарын 1-ний дотор Улсын Их Хуралд оруулж ирэх үүрэг өгсөн заалт одоо санал хураагдах юм.

Ингэхдээ Засгийн газраас саяын энэ гишүүдийн ярьж байгаа одоо жишигээр одоо тусгай албад бол бүгд тусдаа хуультай. Жанжин штаб байна хил байна ингээд шууд тагнуул байна. Энэ чинь ингээд сонсголоор ордог албан тушаал биш. Тийм учраас энэ одоо АТГ-ын удирдлагууд ч гэсэн ийм байхгүй юу. Тийм учраас энийг одоо их анхаарч нэгэнт хувьчлагдсан энэ үзэл баримтлалын хүрээнд бас хэрэгжүүлж орж төлөвлөгөөний төслөө оруулж ирээрэй

гэдэг ийм чиглэлийг бас ажлын хэсэгт өгч байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж заасан. Энэ үндэслэлээр 2 санал хураалт байгаа.

Горимоор эхлээд санал хураалт явуулъя.

100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг тус Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасгай.”

Санал хураалт.

100 хувийн саналаар санал

дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзвэл гэдэг горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “хугацаанаас өмнө” гэсний өмнө “шүүхийн магадлалаар” гэж нэмэх.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу дараах санал хураалтыг явуулна:

1.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасаж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийн урсгал зардлын хэмжээг өмнөх оны батлагдсан төсвөөс бууруулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал хураалт.

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Авлигатай тэмцэх үндэсний

хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Сэргэлэн гишүүн унших уу? Сандаг-Очир гишүүн уншиж танилцуулна.

13.33 цагт

Дараагийн асуудалдаа оръё оо. Ажлын хэсэгт баярлалаа.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржоос ирүүлсэн хүсэлтийг хэлэлцье.

Хүсэлтийг та бүхэнд уншиж сонсгоё оо.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржоос Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа

Хүсэлт гаргах тухай

Миний бие 61 нас хүрч нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарах болзол хангаад байгаа билээ.

Отгон хүүгийн биеийн байдал ядруу байнгын асаргаа сувилгаа хэрэгтэйн дээр гадаад, дотоодын эмнэлгээр эмчилгээ хийлгэх шаардлагатай байгаа юм аа.

Иймээс ар гэрийн гачигдалтай байдлаас хамааран өндөр насны тэтгэвэрт гарах болсон шалтгаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалтын дагуу үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргаж байна аа.

Миний хүсэлтийг хүлээн авч намайг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Хүсэлт гаргасан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддорж.

2023 оны 6 дугаар сарын 27 гэсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103.1-д Цэцийн гишүүн эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг эсхүл Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэнтэй холбогдуулж гишүүнийг чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүйн байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржоос Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн хүсэлттэй холбоотойгоор анх илгээсэн байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн албан бичгийг уншиж сонсгоё оо.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр танаа:

Таны 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн УИХ 13/5867 дугаар албан бичгээр ирүүлсэн асуудалтай Монгол Улсын Ерөнхийлөгч танилцсан бөгөөд тусгайлан өгөх саналгүй байна аа.

Дарга Содбаатар гэсэн албан бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлснийг та бүхэнд танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103.2-т Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар 7 хоногийн дотор хэлэлцэн нууц санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно гэж заасан байна.

Санал хураалт явуулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржийн Монгол Улсын Их Хуралд 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн өөрийнх нь хүсэлтийг нь дэмжиж чөлөөлье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

90 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

13.38 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА